



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/399

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлалсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.5, 2.1.6, 4.1 дэх заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн 25 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь :

1.Цээл, Цогт, Шарга, Баян-Уул, Дэлгэр, Чандмань сумдын улс, аймгийн аварга малчдад хүндэтгэл үзүүлж батламж олгох, Алдарт эхийн 1, 2 дугаар одон гардуулах ёслолоор ээжүүдэд хүндэтгэл үзүүлэхэд шаардагдах 3,399,000 (гурван сая гурван зуун ерөн есөн мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т зөвшөөрсүгэй


2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

ОАМГАЛАНБААТАР



Аймгийн Засаг даргын 20<sup>22</sup> оны 06  
дугаар сарын 28 -ны өдрийн 309 дугаар  
захирамжийн хавсралт



### ЗАРДЛЫН ТООЦОО

№	Зардлын төрөл	Хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Алдарт эхийн 1, 2 дугаар одонгийн хүндэтгэл	198 ширхэг	8,000	1,584,000
2	Улс, аймгийн аварга малчины батламж	200 ширхэг	9,075	1,815,000
Нийт дүн:				3,399,000

\_\_оОо\_\_